

## **ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ СУДАЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3 дах заалтад нийцүүлэн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/ -д заасны дагуу дараах байдлаар хийж гүйцэтгэлээ.

### **Нэг. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Аргачлалаас сонголоо.

Хуулийн төсөл нь улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс тодорхой зардал гарахыг шаардахгүй, мөн ямар нэг эрх, үүрэг, шинэ чиг үүрэг бий болгоогүй, иргэдэд ачаалал үүсгэхгүй тул Аргачлалд заасан дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгох шаардлагагүй гэж үзсэн болно. Үүнд:

- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Зардал

Харин Аргачлалд заасан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Практикт хэрэглэх боломж
- Ойлгомжтой байдал
- Харилцан уялдаа

### **Хоёр. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал**

#### **2.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлсэн байдал**

Тус шалгуур үзүүлэлтийн шалгах хэрэгсэл нь “зорилгод дүн шинжилгээ хийх” юм. Хуулийн төслийн зорилго нь өсвөр насны хүүхдийн эрх зүйн байдлыг Эрүүгийн хуульд өмнөх хуулийн зохицуулалтаас дордуулсан байгаа байдлыг өөрчилж, сайжруулах юм.

2002 оны Эрүүгийн хуулиар насанд хүрээгүй хүүхдийн хувьд хорих ял оногдуулсан шийтгэлийг гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр тэнсэх, хойшлуулах зохицуулалт байсныг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-иар зөвхөн “хөнгөн гэмт хэрэг” гэж хязгаарласан нь өсвөр

насны хүний эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт болсон гэж хуульч, шүүгч, салбарын мэргэжилтнүүд үзэж байгаа ба энэ нь практикт нэлээдгүй асуудал дагуулж байна. Түүнчлэн энэ нь 18 нас хүрээгүй хүүхдийг аль болохоор хорихоос өөр ялаар шийтгэх хувилбарыг баримтлах олон улсын гэрээ, конвенци, пактын зарчимд огтхон ч нийцэхгүй байгаа хэмээн шүүмжлэлтэй хандаж байна.

Дээрх шаардлага, үндэслэл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой туссан байх ба хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь зорилгыг бүрэн хангахаар байна. Тухайлбал, өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгээр зохицуулагдаж буй бөгөөд өсвөр насны хүнд гэмт хэргийн ангилалаас шалтгаалж ял оногдуулахтай холбоотой заалтууд нь 8.1.4, 8.6.1, 8.7.1 дэх заалтууд байна. Эдгээр заалтуудыг өөрчлөх, хүчингүй болгохоор хуулийн төсөлд төсөлд тусгасан нь хуулийн төсөл зорилгоо хангахаар байна гэж дүгнэлээ.

## **2.2 “Практик хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлсэн байдал**

Эрүүгийн хууль 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчилэн батлагдахаас өмнө хугацаанд хуулийн төслийн санал болгож буй зохицуулалт хэрэгжээд явж байсан ба практикт ямар нэг сөрөг хүндрэл, асуудал гарч байгаагүй болно. Хүүхдийн эрхийн хорооноос 5 жил тутамд ирүүлдэг дүгнэлт, зөвлөмжид энэ зохицуулалтыг сайшаан тэмдэглэж ирсэн байна.

## **2.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлсэн байдал**

Хуулийн төсөл нь хуулийн 1 зүйл заалтыг хүчингүй болгох, 2 зүйл заалтад өөрчлөлт оруулах цомхон бүтэцтэй ба Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримтлан ойлгомжтой томъёологдсон байна.

## **2.4 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлсэн байдал**

№	Асуулт	Хариулт буюу үнэлгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Зорилгыг хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл мөн.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Шинээр нэр томъёо тодорхойлоогүй.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Зөрчилдөх заалт байхгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Давхардаагүй.

6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хэрэгжүүлэх этгээд тодорхой
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Шаардлагатай бүх зохицуулалтыг хамруулсан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Энэ асуудал төсөлд хамааралгүй
9	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Энэ асуудал төсөлд хамааралгүй
10	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Энэ асуудал төсөлд хамааралгүй
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хязгаарласан зохицуулалт байхгүй, хари сайжруулсан зохицуулалт болно.
12	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хангаж байна.
13	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Тусгагдаагүй.
14	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Өөр зүйл заалтаар зохицуулагдаж буй тул төсөлд хамааралгүй.

### Гурав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой илэрхийлэгдсэн, Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэлээ.

Хуулийн төслийн урьдчилсан тандалт судалгааны тайлан болон төслийн үзэл баримтлалд дурдсанчилан Монгол улсын Эрүүгийн хуучин ба шинэ хуулийн зөрлөгт үүссэн олон эмгэг, гажуудлуудын нэгийг засах ач холбогдолтой тус хуулийн төслийг салбарын мэргэжилтнүүд дэмжиж, ард иргэдийн зүгээс ихээхэн хүлээлт дагуулж буй тул хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг яаралтай хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвлөж байна.

\_\_оОо\_\_